

**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

Ангиллын код: 03.080.30

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Төмөр замын буудал Ерөнхий шаардлага	MNS 5635:2020
Service for costumers Railway passenger station General requirements	

Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2020 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

**1. Зорилго**

Энэхүү стандартын зорилго нь төмөр замын буудал, түүгээр үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээний цогцолборыг хөгжүүлэх, ангилал, зэрэглэлийг тогтоох, түүнд тавигдах нөхцөл шаардлагыг тогтооход оршино.

**2. Хамрах хүрээ**

- 2.1 Төмөр замын буудал болон түүний үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлагад хамаарна.
- 2.2 Төмөр замын буудалд үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хяналт тавих эрх бүхий байгууллага, буудлын ажилтан мөрдөж ажиллана.

**3. Норматив ишлэл**

Энэхүү стандартад иш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг үндэслэл болгоно. Үүнд:

- 3.1 MNS 4946:2019 “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”
- 3.2 MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
- 3.3 MNS 5150:2002 “Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага”
- 3.4 MNS 5390:2004 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
- 3.5 MNS 5247:2003 “Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн цогцолбор. Техникийн шаардлага”
- 3.6 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
- 3.7 MNS 4996:2000 “Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага”
- 3.8 MNS 5021-1:2019 “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага”

- 3.9 MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
- 3.10 MNS 4588:2004 “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлага”
- 3.11 БНБД 2.01-85 “Галын аюулгүйн дүрэм”
- 3.12 БНБД 2.08.02-89 “Барилгын норм ба дүрэм”
- 3.13 MNS 5566:2005 “Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”
- 3.14 MNS 5682:2006 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага”
- 3.15 MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага”
- 3.16 MNS 6056:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”

#### **4. Нэр томьёо, тодорхойлолт**

- 4.1 Төмөр замын буудал – Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэх, зорчигч болон ачаа илгээгч, хүлээн авагчдад шаардлагатай үйлчилгээг нэг дор үзүүлэх ажлыг тасралтгүй, хэвийн гүйцэтгэх үйлчилгээний цогцолбор бүхий байгууламж.
- 4.2 Буудлын барилга - тасалбар түгээгүүр, хүлээлгийн танхим, лавлах товчоо, нийтийн хоолны цэг, дэлгүүр, амрах байр, ариун цэврийн өрөө, хүүхдийн танхим, холбоо, шуудан, эмнэлгийн тусламжийн цэг, гар тээш хадгаламж зэрэг зорчигчийн иж бүрэн үйлчилгээ явуулахад зориулсан барилга байгууламж.
- 4.3 Буудлын авто зогсоол – Төмөр замын буудлаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгслийг түр зогсооход зориулагдсан талбай
- 4.4 Зорчигчийн тавцан - зорчигчийг галт тэргэнд суух, буух болон ачаа тээшийг галт тэргэнд ачих, буулгах, зөөвөрлөхөд зориулагдсан тавцан
- 4.5 Саравч-зорчигчдын тавцанг бороо хур, цас, нар, салхинаас хамгаалах хаалт
- 4.6 Ачаа, тээшийн байгууламж - зорчигчдын тээш, ачаа тээшийг хүлээн авах, олгох, хадгалах барилга, талбай, агуулах, төрөл, шинж чанар, жинг шалгах, тодорхойлох төхөөрөмжүүд, галт тэргэнд ачих, буулгах хэрэгслүүд
- 4.7 Гарц – зорчигчийн төмөр зам хөндлөн гарах 1 түвшинд аюулгүй зорчих огтлол.
- 4.8 Зорчигчдын гарц - зорчигчдын тавцанг буудлын барилга болон буудлын авто зогсоолтой холбосон явган хүний зам
- 4.9 Нүхэн гарц - зорчигчдын аюулгүй зорчиход зориулагдсан газар доогуурхи хонгил, зам
- 4.10 Гүүр - зорчигчдын төмөр замаар хөндлөн гарах аюулгүй байдлыг хангах зориулалттай байгууламж

#### **5. Төмөр замын буудалд тавих шаардлага**

- 5.1 Төмөр замын буудалд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:
  - 5.1.1 Барилга байгууламжид тавих шаардлага
    - 5.1.1.1 Төмөр замын буудал нь эрх бүхий байгууллагаас баталсан зураг, төслийн дагуу “БНБД2.08.02-89. Барилгын норм ба дүрэм”-ийг баримтлан баригдсан барилга байгууламжтай байна.

- 5.1.1.2 Буудлын барилгыг галт тэрэгний хөдөлгөөний болон зорчигчийн аюулгүй байдлыг хангасан талбайд төлөвлөлттэй нийцүүлж байгуулна.
- 5.1.1.3 Буудлын барилга нь захын замын тэнхлэгээс 20 м-ээс дотогшгүй зайд байрлах ба зорчигчдын тавцангийн ирмэгээс буудлын барилга хүртэл 50 м-ээс ихгүй байна.
- 5.1.1.4 Буудлын барилга, буудлын авто зогсоолын талбай, зорчигчдын тавцан, саравч, ачаа тээшийн байгууламжууд, зорчигчдын гарц, нүхэн гарц, гүүр, тэдгээрт ашиглаж байгаа тоног төхөөрөмжүүд нь зорчигч, үйлчлүүлэгчийн эрүүл мэнд болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.
- 5.1.1.5 Төмөр замын буудлын барилга байгууламжуудын байрлал, ажил үйлчилгээний зохион байгуулалт нь зорчигч, үйлчлүүлэгчийг галт тэрэгний хөдөлгөөн шууд хийгдэж байгаа зам талбайгаар зорчих, төмөр замыг зориулалтын явган гарцгүй газраар хөндлөн гарахыг үгүйсгэсэн байвал зохино.
- 5.1.1.6 Төмөр замын буудал нь “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 “Авто замын байгууламж. Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. MNS 5537:2016 Техникийн шаардлага” MNS 5682:2006 стандартуудын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 5.1.1.7 Буудлын барилгын таазны өндөр барилгын норм стандартыг хангасан байна.
- 5.1.1.8 Зорчигчдын тавцангийн хэмжээсүүдийг хүснэгтээр харуулав. Тавцангийн өндөр нь ашиглалтын үед хүснэгтэд заагдсан хэмжээнээс ихсэх тал руугаа 20 мм, багасах тал руугаа 50 мм, замын тэнхлэгээс ихсэх тал руугаа 30 мм, багасах тал руугаа 25 мм-ийн хүлцэлтэй байж болно.

Хэмжээс	Өндөрлөсөн	Нам
Өндөр (зам төмрийн толгойн дээд түвшингээс), мм	1100	200
Замын тэнхлэгээс тавцангийн ирмэг хүртэлх зай, мм	1920	1745
Өргөн, м	1-р зэргийн буудалд 6.0 2-р зэргийн буудалд 4.0 3-р зэргийн буудалд 2.0 4-р зэргийн буудалд 1.5	
Тавцан дээр байрлах байгууламжийн гадна ирмэгээс тавцангийн ирмэг хүртэлх зай, м	2.0	

- 5.1.1.9 Зорчигч буух, суух зориулалттай бүх өртөө, зөрлөг зорчигчийн тавцантай байх бөгөөд зорчигчийн тавцангийн урт нь 400 метрээс багагүй байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зорчигчийн тавцантай байна.
- 5.1.1.10 Зорчигчийн тавцангууд өөр хоорондоо болон буудлын барилга ба буудлын авто зогсоолын талбайтай гарц, нүхэн гарц, гүүрээр холбогдсон байвал зохино.
- 5.1.1.11 Саравч нь зорчигчийн ая тухтай байдалд тохирсон байх бөгөөд буудлын зэрэглэлээс хамааран уртын хэмжээг тодорхойлно.
- 5.1.1.12 Буудлын барилга байгууламж нь галын аюулгүй байдлын холбогдох стандартын шаардлагын дагуу галын аюулгүйн таних тэмдэг бүхий аваарын

гарц, бүдүүвч, гал унтраах хэрэгсэлтэй байхаас гадна дотоод хяналтын системийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

- 5.1.1.13 Нүхэн гарцны өргөн 3 м-ээс багагүй, өндөр нь 2,4 м-ээс багагүй байна. Гүүрийн өргөн нь 2,25 м-ээс багагүй байна.
- 5.1.1.14 Нүхэн гарц ба гүүр нь тавцан руу гарах болон тавцангаас буух хоёроос доошгүй гарцтай байх ба тэдгээрийн өргөн нь тухайн нүхэн гарц, гүүрийн өргөнтэй тэнцүү буюу 2.0 м-ээс багагүй байна.
- 5.1.1.15 Тусгайлсан буудлын барилгагүй завсрын жижиг зөрлөгүүд зорчигчдод зориулсан 4 м-ээс доошгүй урттай саравчтай байна.
- 5.1.1.16 Буудлын авто зогсоолын багтаамж нь үйлчилгээний барилга, байгууламжуудын багтаамж болон ажлын горим, зорчигчдын үйлчлэх хэлбэрт тохирсон “Авто зогсоол, Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342:2007 шаардлагад нийцсэн байна.
- 5.1.1.17 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орох, гарах хаалга, гүүр, нүхэн гарцын хэсэгт налуу шаттай, тусгай зориулалтаар тоноглогсон ариун цэврийн өрөө, нийтийн үйлчилгээний байранд хамгийн ойр байрлалд авто зогсоолын талбайтай байна.
- 5.1.1.18 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд галт тэргэнд суух үед зорчигчийн тавцан, вагоны хаалгатай ижил бус түвшинд байрлаж байвал уулзварын өндөр нь 760 мм тутамд 8.33%-ийн налуу бүхий 1500 мм\*1500 мм хэмжээтэй налуу хавтантай байна.

### **5.1.2 Аюулгүй байдлын шаардлага**

- 5.1.2.1 Төмөр замын буудал нь “Галын аюулгүй байдал.Ерөнхий шаардлага. MNS 4244:94” стандарт, “БНБД 2.01-85.Галын аюулгүйн дүрэм”-ийн шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.1.2.2 Төмөр замын буудлын барилга байгууламж нь MNS 5566:2005 “Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”, MNS 6575:2016 “Гал түймрээс хамгаалах. Барилгын гадна талын суурин шат. Дээврийн хязгаарлагч. Техникийн шаардлага”-ыг тус тус хангасан байна.
- 5.1.2.3 Төмөр замын буудалд ашиглах тоног төхөөрөмж, цахилгааны шугамын суурилуулалт, угсралтыг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгэсэн байна.
- 5.1.2.4 Буудлын барилга нь онцгой байдлын үед анхааруулга дуун дохио өгөх хэрэгсэлтэй байна.

### **5.1.3 Эрүүл ахуйн шаардлага**

- 5.1.3.1 Буудлын барилга доторхи байруудын дулааны хэм +18С-аас +25С, харьцангуй чийглэг 40%-иас 60%, шуугианы түвшин 50 дБ-аас 70 дБ байхыг хэвийн гэж үзнэ.
- 5.1.3.2 Буудлын барилга доторхи ажлын байруудад нэг хүнд ноогдох талбай 8 м<sup>2</sup>-ээс багагүй, ажлын байрны эзлэхүүн 20 м<sup>3</sup>-ээс багагүй, агаар сэлгэлт цагт 30 м<sup>2</sup>-ээс багагүй байна.
- 5.1.3.3 Төмөр замын буудлын гадна орчин, зорчигчийн тавцан, нүхэн гарц, гүүр нь шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байх ба буудлын барилгын дотоод байруудын

гэрэлтүүлэг нь байгалийн гэрэлтэй бол 300 лк-ээс доошгүй, хосолсон эх үүсвэртэй бол 750 лк-ээс доошгүй байна.

- 5.1.3.4 Буудлын барилгын дотоод танхим, байруудад өдөр тутам чийгтэй цэвэрлэгээг эрүүл ахуйн холбогдох стандартад нийцсэн халдваргүйтгэлийн бодисоор хийж байна.
- 5.1.3.5 Төмөр замын буудлын орчны талбай, барилга байгууламжийн засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны үзлэг, хог хаягдал зайлуулалт, хортон шавьжны урсгал зэргийг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын зохих норм, журам, дүрмийн дагуу хийнэ.
- 5.1.3.6 Төмөр замын буудлын үйлчилгээнд хэрэглэх ундны ус нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. MNS 0900:2018” стандартын шаардлагыг бүрэн хангасан байна. Улирал тутам мэргэжлийн байгууллагад дээжийг өгч шинжилгээ хийлгэсэн байна.
- 5.1.3.7 Төмөр замын буудлын хоолны газар нь “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” MNS 4946:2019 стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 5.1.3.8 Нийтийн хоолны үйлчилгээнд эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартын дагуу хадгалж, боловсруулсан түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх ба хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд нийтийн хоолны эрүүл ахуйн нийтлэг дүрмийг мөрдөж, хоолноос дээж авч, бүртгэл хөтөлнө.

#### **5.1.4 Хүрээлэн буй орчин, тохижилтод тавих шаардлага**

- 5.1.4.1 Төмөр замын буудлын үйлчилгээний байгууллага нь хүрээлэн буй орчныг хайрлан хамгаалж, нөхөн сэргээх, ус, агаар, хөрсийг бохирдуулахгүй байх арга хэмжээ авна. Хөрсний шинжилгээг хагас жил тутам 1 удаа мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгүүлсэн байна.
- 5.1.4.2 Буудлын барилгын орчин нь мод, бут, сөөг, зүлэг, цэцгийн мандал, амрах сандалтай байна.
- 5.1.4.3 Зорчигчийн тавцан, гарц, нүхэн гарц, гүүр зэргийг хог, шороо, тоос, цас, мөс зэргийг байнга цэвэрлэсэн байна.

#### **5.1.5 Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага**

- 5.1.5.1 Төмөр замын буудлын ажилтнууд нь үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн байна.
- 5.1.5.2 Зорчигчтой шууд харьцан ажилладаг үйлчилгээний ажилтнууд нь Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байна.
- 5.1.5.3 Төмөр замын буудлын ажилтнууд нь жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, эрүүл болох нь нотлогдсон байна.
- 5.1.5.4 Төмөр замын буудлын ажилтнууд нь аюулгүй ажиллагааны болон эмнэлгийн анхны тусламжийн зохих мэдлэгтэй байна.
- 5.1.5.5 Зорчигчтой шууд харьцан ажилладаг үйлчилгээний ажилтнууд нь өөрийн овог нэр, албан тушаал бүхий энгэрийн тэмдэг, дүрэмт хувцастай байна.

### **6. Төмөр замын буудлын зэрэглэл, үйлчилгээ**

6.1 Төмөр замын буудлыг нэг удаагийн цугларах зорчигчид болон үдэн гаргагч, угтан авагчдын тоо, зорчигч урсгалын хэмжээ, барилга байгууламжийн багтаамжаас хамааруулан дараах ангиллын байна. Үүнд:

№	Ангилал	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	4-р зэрэг
1	Нэг удаагийн цугларах зорчигч, үдэн гаргагч, угтан авагчдын хэмжээ	1500 хүнээс цөөнгүй	700-аас 1500 хүн	200-аас 700 хүн	200 хүртэл
2	Үйлчилгээний талбайн хамгийн бага хэмжээ	1000 м2	600 м2	300 м2	
3	Саравч	Зорчигчийн тавцангийн нийт уртын дагуу байна.	100 м-ээс доошгүй	Буудлын барилгын уртаас багагүй	
4	Нийтийн үйлчилгээний байртай эсэх	Шаардлагатай		Байж болно	
5	Нийтийн бие засах газар	Нийтийн үйлчилгээний байранд эрүүл ахуйн шаардлага хангасан зохих хэрэгслээр тоногдсон эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байна.		Шаардлага хангасан зайд тусдаа байж болно.	
6	Хоолны газар	<ul style="list-style-type: none"> <li>- Түргэн үйлчилгээний ресторан</li> <li>- Кафе</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>- Түргэн хоолны газар</li> <li>- Цайны газар</li> </ul>	
7	Зочид буудлын үйлчилгээ	Байж болно		Шаардлагагүй	
8	Худалдаа үйлчилгээ	Супермаркет Дэлгүүр	Дэлгүүр Мини маркет		Лангуу
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, тавцан	Шаардлагатай			
9	Буудлын авто зогсоолын хэмжээ /га/	1,25 га-аас багагүй	1 га-аас багагүй	0,7 га-аас багагүй	0,3 га-аас багагүй
10	Гэрэлтүүлэг				

6.2. Төмөр замын буудалд дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

№	Үйлчилгээний төрөл	Нийтийн үйлчилгээний байранд			
		1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	4-р зэрэг
1	Үндсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Тасалбар худалдах газар</li> <li>- Кассын танхим</li> <li>- Тээшийн касс</li> <li>- Мэдээллийн лавлах</li> <li>- Хүлээлгийн танхим</li> <li>- Эмнэлгийн анхны тусламж</li> <li>- Эх нялхсын өрөө</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>- Тасалбар худалдах газар</li> <li>- Кассын танхим</li> <li>- Тээшийн касс</li> <li>- Хүлээлгийн танхим</li> <li>- Ундны ус</li> <li>- Нийтийн бие засах газар</li> </ul>	

		<ul style="list-style-type: none"> <li>- Холбоо, мэдээллийн үйлчилгээ</li> <li>- Ачаа тээшийн байр</li> <li>- Ундны ус</li> <li>- Хоолны газар</li> <li>- Цагдаагийн өрөө</li> <li>- Нийтийн бие засах газар</li> </ul>	
2	Нэмэлт үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Шуудан</li> <li>- Гар тээш хадгаламж</li> <li>- Амрах байр</li> <li>- Тусгай үйлчилгээний танхим</li> <li>- Видео танхим</li> <li>- Сервис-төв</li> <li>- Тамхи татах цэг</li> <li>- Даатгал</li> <li>- АТМ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гар тээш хадгаламж</li> <li>- Тамхи татах цэг</li> <li>- АТМ</li> </ul>

## **7. Төмөр замын буудлын үйлчилгээнд тавих шаардлага**

- 7.1 Төмөр замын буудлын нийтийн үйлчилгээний байр болон дагалдах байгууламжид үзүүлэх үйлчилгээ нь холбогдох стандартын шаардлага хангасан байна.
- 7.2 Төмөр замын буудал нь зорчигчдын тавцан, ажлын байруудыг цэвэрлэх, ачаа тээшийг ачих, буулгах, зөөвөрлөх техник хэрэгсэл, тасалбар түгээх болон байр хуваарилах автоматжуулсан систем, теле хяналтын сүлжээ, чанга яригч, мэдээллийн самбар, лавлах төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна.
- 7.3 Буудлын барилга нь тухайн өртөө, суурин газрын нэр, хаягтай, тэдгээр нь шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байна.
- 7.4 Галт тэрэгний хөдөлгөөн хийгдэж байгаа, тээшийн ачилт-буулгалтын ажиллагааг гүйцэтгэж байгаа аюултай бүс, зам, талбайд сэрэмжлүүлэг, анхааруулах самбар, зорчихыг хориглосон тэмдэглэлүүдийг байрлуулсан байна.
- 7.5 Зорчигчдын тавцан, нүхэн гарц, гүүр болон буудлын барилга дотор цаг, галт тэрэгний аяллын болон тасалбар түгээгүүр ба тээш хадгаламжийн ажлын цагийн хуваарь, тасалбарын болон тээшийн үнийн жагсаалт, төмөр замын буудлын зохион байгуулалтын бүдүүвч зураг, зар мэдээллийн самбар, теле дэлгэц, үйлчилгээний цэгүүдийг томьёолсон тэмдэглэл хаягийг үзэгдэхүйцээр байрлуулсан байна.
- 7.6 Төмөр замын буудлын үйлчилгээний байгууллага нь үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, буудлын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, дэг журмыг чанд сахиулах арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу байнга хэрэгжүүлж ажиллана.
- 7.7 Буудлын барилга нь 24 цагийн үйл ажиллагаатай нийтийн бие засах газартай байна. Нийтийн бие засах газар нь буудлын зэрэглэлээс хамааран нийтийн үйлчилгээний байранд болон тусдаа байж болно.
- 7.8 Ачаа тээш, гар тээш хадгалах үйлчилгээ нь зорчигчийн тээшийг хүлээн авах, хадгалах, олгох тусгай өрөө, эсвэл автомат хайрцагтай байна.
- 7.9 Тээш хадгалах өрөө нь тавиуртай, өрөөний хэмийг тохируулах боломжтой байна.
- 7.10 Ачаа тээш, гар тээш хадгалах тавиур нь давхар хоорондоо 0,7 м-ээс багагүй зайтай, 3-аас дээшгүй давхар байх ба тавиур хоорондын сул зай нь 1,2 м-ээс багагүй өргөнтэй байна.

- 7.11 Буудлын барилга доторхи үйлчилгээний цэгүүд нь зорчигчдын урсгал хөдөлгөөнд саад учруулахгүйгээр байрласан байна.
- 7.12 1 ба 2-р зэргийн буудал нь эмнэлгийн анхны тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 7.13 Хүлээлгийн болон хүүхдийн танхим, видео танхим, сервис-төв, мэдээллийн төв нь үйлчлүүлэгчдэд тав тухтай амрах, үйлчлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байх ба ундны усаар үйлчлэх үйлчилгээ байх бөгөөд ундны ус нь MNS 0900:2005 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага” хангасан байна.
- 7.14 Эх нялхсын өрөө нь бусад үйлчилгээний үйлчилгээний цэгүүдээс тусдаа хүүхэд амрах, хооллох, өлгий, хувцас, живхийг солих боломжийг бүрдүүлсэн байхаар зохион байгуулна.
- 7.15 Мэдээллийн лавлах нь чанга яригч ашиглан, галт тэрэгний дугаар, бүрэлдэхүүн, аяллын хуваарь, хүлээн авах-явуулах зам, тавцангийн дугаар, бусад журмыг тогтмол мэдээлж байна.
- 7.16 Тасалбар түгээгүүр, тээшийн үйлчилгээний ажиллах цагийн хуваарийг галт тэрэгний цагийн хуваарьтай уялдуулсан байна.
- 7.17 Төмөр замын буудлын зэрэглэлээс хамааран ресторан, кафе, буфет, түргэн хоолны газар, цайны газар зэрэг үйлчилгээг үзүүлж болно. Төмөр замын буудал дахь хоолны газар нь “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” MNS 4946:2019 стандартын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 7.18 Худалдааны газар нь “Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS 5021:2007 стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.
- 7.19 Амрах байр нь “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4588:2004” стандартын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 7.20 Буудлын барилга доторхи танхимууд, зорчигчдын тавцан, нүхэн гарц, гүүр, явган гарцын 100 м<sup>2</sup> тутамд хогийн сав нэг ширхгийг байрлуулна.
- 7.21 Буудлын авто зогсоол нь “Авто зогсоол, Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342:2007 стандартын шаардлагад нийцсэн байна.
- 7.22 Төмөр замын буудал нь тамхи татахад зориулсан тусгай байртай байх ба агааржуулалтын системтэй байна. үүнээс бусад газарт тамхи татахыг хориглоно.

ТӨГСӨВ